



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 11 өдөр

Дугаар 9/112

Мандалговь

Архи, согтууруулах ундаа худалдаалах
түүгээр үйлчлэхгүй байх өдөр
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "ж" дэх заалт , Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн A/281 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1."Архигүй амьдралыг цогцлооё" арга хэмжээний хүрээнд Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт 2021 оны 10 сарын 01-ний өдрийг дуусталх хугацаанд аймгийн хэмжээнд сар бүрийн 01, 15, 25-нд архи, согтууруулах ундаа худалдаалахгүй, түүгээр үйлчлэхгүй байхаар тогтоосугай.

2.Архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, баяр ёслол, хурим найр, тэмдэглэлт өдрийг архи, согтууруулах ундаагүйгээр тэмдэглэн өнгөрүүлэх, эрүүл мэндээ хамгаалж нийгэмд үзүүлэх хор уршгаас урьдчилан сэргийлэхийг сумын нийт иргэдэд уриалсугай.

3.Архи, согтууруулах ундааны хэрэглээг иргэдийн дунд бууруулах, эрүүл мэнд , эдийн засаг, нийгэмд үзүүлэх хор уршгаас сэргийлэх, архи, согтууруулах ундааны шууд болон шууд бус хор нөлөөллийн талаар нийт хүн амд мэдээлэл өгөх, хязгаарласан цагийн хуваарийг мөрдүүлэн ажиллахыг ЭМТөв, Багийн засаг дарга нар, ХҮҮХариуцсан мэргэжилтэн, Хэсгийн байцааг нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (И.Эрдэнэцог)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ